

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН

ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар/

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийн хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал байхгүй болно.

Харин "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах зээлийн хөрөнгийн зардал гарахаар байна. Үүнд:

- Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл" нь нийт 110 сая ам.долларын төсөвт өртөгтэй бөгөөд Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-аас олгох 100 сая ам. долларын зээл нь жилийн Баталгаат овернайт хүүгийн түвшин /SOFR/¹ дээр 1.30 хувийн нэмэгдэл бүхий хувьсах хүүтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй.
- Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-аас олгох 7.3 сая зээлжих тусгай эрх (10 сая орчим ам.доллар) нь ОУХА-аас олгох зээл нь жилийн 2 хувийн тогтмол хүүтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй болно.

—ооо—

¹ Secured Overnight Financing Rate буюу баталгаат овернайт санхүүжилтийн хүү.